



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/440

Хэрлэн сум

“Чингис фестиваль-2023” соёлын биет бус  
өвийн их наадмыг зохион байгуулахад  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 15 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.6.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Чингис фестиваль-2023” соёлын биет бус өвийн их наадмыг Чингис хотод зохион байгуулахад шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Хэнтийн түүх- бидэнд чухал” арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-д гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

**СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ИХ  
НААДМЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ**

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ	Тайлбар
1	Найрууллагчийн хөлс	ш	1	2,500,000	2,500,000	Соёлын биет бус өвийн уламжлалт ахуйн, орчныг бүрдүүлж, язгуур хэв шинж, нутгийн болон угсаатны онцлогийг харуулсан үзүүлэх тоглолт найруулах
7	Мэргэжлийн урлагийн байгууллагын ажилчдын ажил гүйцэтгэлийн хөлс	ш	15	300,000	4,500,000	15 хүн*3 хоног /1 өдрийн 100000/
9	Шагналд олгогдох дурсгалын зүйл	л	20	100,000	2,000,000	Фестивальд оролцсон шилдэг 20 оролцогчдод дурсгах дурсгалын зүйл
8	Фестивалийн хүндэт өргөмжлөл	ш	20	32,000	640,000	Шилдэг 20 оролцогчийн өргөмжлөлийн үнэ
11	Сурталчилгаа, болон хөтөлбөрийн хулдаасан хэвлэл	ш	2	180,000	360,000	Фестивалийн тайзны арын болон хөтөлбөрийн хулдаасан хэвлэл
					<b>10,000,000</b>	

2023 оны 08 дугаар сарын 11-ны  
 А/1770 дугаар захирамжийн хавсралт

  
 Аймгийн Засаг даргын  
 дугаар сарын 11-ны  
 А/1770 дугаар захирамжийн хавсралт